



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/166

Мандалговь

“Мэйжүрмэнт” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/17 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд механик хэмжлийн эталон болон газын түгээгүүр шалгах багц тоног төхөөрөмж /Сайнцагаан сум/” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мэйжүрмэнт” ХХК-тай 29,700,000 (хорин есөн сая долоон зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд механик хэмжлийн эталон болон газын түгээгүүр шалгах багц тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мэйжүрмэнт” ХХК-ний захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210704